



## **САМБУУГИЙН МӨНХЖАРГАЛ**

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга  
1978-1990 он

Хуучин Түшээт хан аймгийн Ахай гүний хошуу, одоогийн Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сумын нутаг Бүрэнхаан уулын өвөр, Амарбаясгалант хийдийн хөлд 1941 онд төржээ. Тэрбээр 1949-1959 онд бүрэн дунд сургууль, 1959- 1965 онд ЗХУ-ын Москва хотын архитектурын дээд сургууль төгссөн.

1965-1972 онд Улсын барилгын зургийн төв институтэд архитектор, ерөнхий инженер, захирал, 1972-1978 онд БНМАУ-ын СнЗ-ийн дэргэдэх Улсын төлөвлөгөөний комиссын орлогч дарга, 1978-1990 онд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, 1990-1991 онд Үндэсний хөгжлийн яамны нэгдүгээр орлогч бөгөөд төрийн сайд, газрын дарга, ерөнхий экспертээр ажиллаж байгаад хувиараа аж ахуй эрхлэн одоо “ЭБ-3” ХХК,

“Амарбаясгалант” зочид буудлын ерөнхий захирлаар ажиллаж байна.

МАХН-ын XVIII, XIX онц их хуралд төлөөлөгчөөр оролцож, мөн хурлаас МАХН-ын Төв Хорооны гишүүнээр сонгогдсон. БНМАУ-ын АИХ-ын IX, X, XI дэх удаагийн сонгуулиар АИХ-ын депутат, Улаанбаатар хотын намын бага хурлуудад төлөөлөгчөөр оролцож, хотын намын хорооны товчооны гишүүн, Улаанбаатар хотын АДХ-ыг сонгох 12, 13, 14, 15 дахь удаагийн сонгуулиар хотын АДХ-ын депутатаар сонгогдож байжээ.

Түүний ажлын үр бүтээлийг үнэлж, “Алтан гадас” одонгоор хоёр удаа, “Хөдөлмөрийн хүндэт медаль”, бусад ойн медалиуд, гадаад орнуудын одон медалиудаар шагнажээ. 1999 онд “Улаанбаатар хотын хүндэт иргэн” цол хүртсэн юм